



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дугаар сарын 02

Дугаар 01/02

Жаргалант сум

Хяналтын зөвлөлийн даргыг
томилох тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь заалт, 4.3 дахь хэсгүүдийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн Ээлжит I хуралдаанаас ТОГТООХ нь:

Хоршоо хөгжүүлэх санд хүсэлт ирүүлсэн зээлийн төсөлд хяналт тавих үүрэг бүхий “Хяналтын зөвлөл”-ийн даргаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Жамбаагийн Эрдэнэ-Очирыг томилсугай.

ДАРГА



Ш БИЛГҮҮНБААТАР